



**ХЭНТИЙ АЙМГИЙН  
БАТНОРОВ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ**

2025 оны 05 сарын 16 өдөр

Дугаар A/95

Батноров сум

**Монгол Улсын иргэнд газар  
өмчлүүлэх тухай**


Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2 дахь хэсэг, Монгол Улсын иргэнд газар өмчлүүлэх тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1.1, 14.1.3 дахь заалт, мөн хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1, 21.2 дахь хэсгийн заалтууд, Батноров сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны 12 дугаар сарын 24-ны өдрийн 15 дугаар тогтоолын 2 дугаар хавсралтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Нэг удаа үнэ төлбөргүйгээр газар өмчлөх эрхээ хэрэгжүүлэхээр хүсэлт гаргасан иргэдийн холбогдох материал, газрын даамлын саналыг үндэслэн Батмөнх овогтой Мөнхтуяа иргэнд 700 м<sup>2</sup> газрыг өмчлүүлсүгэй.

2. Иргэдийн өмчилж авсан газарт газрын кадастрын зураглал хийлгэж өмчлөгчдөд нь хүлээлгэн өгч, хяналт тавьж ажиллахыг 7 дугаар баг, Бэрх хотын газрын даамал (Т.Очирбат)-д даалгасугай.

3. Хуулийн дагуу өмчилж авсан газраа үл хөдлөх эд хөрөнгийн улсын бүртгэлд бүртгүүлж, өмчлөгчийн эрх үүргийг хэрэгжүүлж байхыг энэхүү захирамжаар өмчлөгч болсон Б.Мөнхтуяа иргэнд үүрэг болгосугай.

ДАРГА  ОТГОНБАЯР



230425257